



СУМЫН ЗАСАГ ДАРГА, ХЭЛТЭС
АГЕНТЛАГИЙН ДАРГА НАРТ

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛ

81000 Улаанбаатар, Завхан аймаг

Утас-факс: 7046-24-54

2021.12.15 № 49

танийн № т

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг
хангаж, шалгалтын мөрөөр авч
хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар томилогдон ажлын хэсэг 2021 оны 11 дүгээр сарын 1-5-ны өдрүүдэд тус аймагт ажиллаж, төрийн захиргааны 21 байгууллагын 500 төрийн захиргааны албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлагын шийдвэрт хяналт, шалгалт хийж, шалгалтын дүнг Төрийн албаны зөвлөлийн 47 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэгт "Зөвлөл эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоол гаргана. Зөвлөлийн шийдвэрийг холбогдох этгээд заавал биелүүлнэ" хэмээн хуульчилсан бөгөөд хяналт шалгалтын явцад шалгалтад хамрагдсан 15 байгууллагын 78 албан хаагчийг Төрийн албаны тухай хууль тогтоомж зэрчиж төрийн жинхэнэ албан тушаалд томилсоныг тогтоож, зөрчил арилгуулах хугацаатай үүрэг өгөөд байна.

Иймд аймгийн хэмжээний төрийн захиргааны байгууллагууд дараах арга хэмжээ авч, Төрийн албаны тухай хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг чиглэл болгож байна.

Үүнд 1. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн албаны сул орон тоог чадахуйн зарчмыг баримтлан сонгон шалгаруулалтын үндсэн дээр Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны дагуу нөхөх;

2. Төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог хуулийн дагуу нөхөж томилогдох хугацаанд түүний албан үүргийг Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан журамд нийцүүлэн түр орлон гүйцэтгүүлэх;

3. Төрийн албаны зөвлөлөөс тогтоосон хугацаанд томилсон шийдвэрийг хүчингүй болгоогүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр хуульчилсан байдгийг анхаарч ажиллах;

4. Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-д нийцүүлэн төрийн албан хаагчийн хувийн хэргийг бүрдүүлж, баяжилтыг тухай бүр хийж хэвших;

5. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянуулсан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилох эсэх асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх;

6. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", баримт бичгийн стандартыг үйл ажиллагаандаа мөрдөх;

7. Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу төрд учруулсан хохирлыг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн телүүлэх тухай хуулийн зохицуулалтыг анхаарч ажиллах;

8. Байгууллагын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн зөвлөлөөс хийж хэрэгжүүлсэн ажлыг дээд шатны байгууллагад тайлagnаж хэвших;

9. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, сургаж дадлагажуулах чиглэлээр жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, үр дүнг тайлagnаж ажиллах.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журамд заасны дагуу салбар зөвлөлийн бүрэлдэхүүн Төрийн албаны зөвлөлийн баталсан удирдамжийн хүрээнд сумдын Засаг даргын Тамгын газар болон шалгалтад хамрагдаагүй төрийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж, томилох үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлагын шийдвэрт ойрын хугацаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөөд байна.

Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийн удирдлагын шийдвэр гаргаж ажиллахыг үүгээр анхааруулж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 350 дугаар тогтоолыг хавсаргав.





**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны II сарын 16 өдөр

Дугаар 350

Улаанбаатар хот

Г 7
**Хяналт шалгалтын мөрөөр авах
арга хэмжээний тухай**

Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.3, 66.1.6 дахь заалт, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 2.1.1, 3.1.2."в", 4.5 дахь заалт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд зөрчилгүй, ёс зүйтэй төрийн байгууллага, сум шалгаруулах болзолт уралдаан, "Ес зүйг эрхэмлэсэн төрийн албан хаагч байя" уриалга гаргаж, аян зохион байгуулан ажиллаж байгааг сайшаан тэмдэглэсүгэй.

2. Завхан аймгийн төрийн захиргааны байгууллагын зарим удирдах, гүйцэтгэх албан тушаалд томилсон энэхүү тогтоолын 1-15 дугаар хавсралтад дурдсан шийдвэр Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14, 15, 16, 17 дугаар тогтоолоор тус тус баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албаны еренхий шалгалт өгөх болзол, журам", "Төрийн албан тушаалд шатлан дэвшиүүлэх журам", "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам", Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын холбогдох заалтыг тус тус зөрчсөнийг тогтоосугай.

3. Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 1 дүгээр, Нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 2 дугаар, Боловсрол, соёл урлагийн газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 3 дугаар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 4 дүгээр, Санхүүгийн хяналт, аудитын албаны албан хаагчийн нэр, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 5 дугаар, Стандарт хэмжилзүйн хэлтсийн албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 6 дугаар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 7 дугаар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 8 дугаар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 9 дүгээр, Мал эмнэлгийн газрын албан хаагчдын нэрс,

албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 10 дугаар, Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 11 дүгээр, Улиастай сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 12 дугаар, Биеийн тамир, спортын газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 13 дугаар, Эрүүл мэндийн газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 14 дүгээр, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын албан хаагчдын нэрс, албан тушаал, шийдвэрийн жагсаалтыг 15 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


4. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий албан хаагч, иргэдийг томилсон шийдвэрийг хүчингүй болгохыг томилох эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

5. Төрийн албаны зөвлөлөөс тогтоосон хугацаанд томилсон шийдвэрийг хүчингүй болгоогүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 32 дүгээр зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, буруутай албан тушаалтныг үүрэгт ажлаас чөлөөлөх мэдэгдлийг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлэхийг урьдчилан мэдэгдсүгэй.

6. Энэхүү тогтоолын биелэлтийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Төрийн албаны зөвлөлд ирүүлж, уг тогтоолын хэрэгжилтийг танилцуулж, тайлагнахыг Завхан аймгийн Засаг дарга болон томилох эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ц.Амартөгс/, Төрийн албаны зөвлөлийн Завхан аймаг дахь Салбар зөвлөлд тус тус даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ